

2021 оны 04 сарын 21-ны өдөр

№ 01/2021.

Улаанбаатар хот

*Компанийн жилийн үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайлангийн талаархи  
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11, 62 дугаар зүйлийн 62.1.9, “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.9, 8.14 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 дүгээр сарын 21-ны одрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/2021 тоот тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Түмэн шувуут” хувьцаат компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ЭРХЭМБАЯР

Түмэн шувуут ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлын 2021 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн  
01/2021 тоот шийдвэрийн хавсралт

## **“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ**

*ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны зорилго нь: Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах, аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.*

“Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2020 оны 05 сарын 25-ны өдрийн 08/2020 тоот тогтоолоор байгуулагдсан Аудитын хороо нь дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

*Аудитын хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Ц.Наран-Учрал*

*Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Мөнх-эрдэнэ*

*ТУЗ-ийн ердийн гишүүн Ж.Болд*

“Түмэн шувуут” ХК нь 2020 оны санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд аудит хийлгэхээр “Гранд Торнтон” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, ТУЗ-ийн даргаар батлуусан байна.

Энэ онд тус хороо нь компанийн санхүүгийн хяналтын тогтолцоог сайжруулах үндсэн чиг үүргийнхээ дагуу улирал бүрийн санхүүгийн тайлантай танилцаж үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглүүлэн ажиллалаа. Цаашид хяналтын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын горимуудыг нэвтрүүлэх, “Түмэн шувуут” ХК-ийн дотоод аудитын дүрмийг олон улсын стандартад нийцүүлэн гаргахаар боловсруулан ажиллаж байна.

Аудитын хорооны хурлаар тус хувьцаат компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт хийхдээ Гүйцэтгэх захирал Ж.Болдын илтгэл, мөн аудит хийсэн байгууллагын дүгнэлт, компанийн санхүүгийн албанаас гаргуулсан мэдээ, мэдээллийг үндэслэл болгов.

**Дүгнэх нь:** 2020 онд дэлхийг хамарсан цар тахлын аюулт өвчин дэгдсэнээр урд өмнө тулгарч байгаагүй олон шинэ хүндрэл бэрхшээл улс орны хэмжээнд болон бизнес, нийгмийн оролцогч тал бүрт тулгарсан юм. Монгол улсын хувьд ч олон удаагийн хөл хорио тогтоож, үйл ажиллагааны чиглэлээс хамаарч бизнесийн олон салбар бүрэн зогсох хэмжээнд асуудал нь хүндэрч, ажлын байр цомхотгох, зээлээ эргүүлэн төлөх боломжгүй байдал үүссэж байгааг энд дурдах нь зүйтэй байх. Харин манай Түмэн Шувуут ХК-н хувьд цар тахлын сорилттой амжилттай тэмцэж, өөрийн хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, борлуулалт, ашиг орлогоо нэмэгдүүлэн ажиллаж чадлаа. Үүнд чадварлаг удирдлагын баг, хамт олны цаг тухай бүрт нь гаргаж байсан оновчтой шийдвэр гаргалтыг онцгойлон тэмдэглэх нь зүйтэй. “Түмэн шувуут” хувьцаат компани 2020 онд 73,8 сая ширхэг өндөг үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос 27%-иар өссөн бол малын тэжээлийн үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад 19%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. “Түмэн шувуут” ХК нь 2019 онд 3,2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бол 2020 онд 4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Борлуулалт нэмэгдэж, компанийн цэвэр ашиг өссөн нь цаг үеийн нөхцөл байдлаас гадна компанийн нэр хүнд, зах зээлд эзлэх байр суурь нэмэгдсэн, үүнд маркетингийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлого, тодорхой ажлууд, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотой нийт ажлууд нөлөөлсөн гэж үзэж байна.

Мөн 2020 онд нийт 0,8 мян/тн бордоо үйлдвэрлэж 88,3 сая төгрөгийн борлуулалттай ажилласан байна. БНБУ-ын Dion engineering компанийн тоног төхөөрөмж бүхий шингэн өндөгний үйлдвэрлэлийг эхлүүлж зах зээлд нийлүүлж эхэлсэн нь үйл ажиллагаагаа өргөтгөж шинэ бүтээгдэхүүн, өндөгний төрлөө нэмэгдүүлсэн томоохон ажил болсныг илтгэж байна. Мөн СХД-ийн 21 дүгээр хороо, Их булагт байрлалтай шинэ шувууны аж ахуйд 2 байрыг ашиглалтад оруулан 12 ажилтантай анхны 40,000 дэгдээхий хүлээж авч бойжуулсан нь 2020 оны үйлдвэрлэлийн тоог өсгөхөд тодорхой хувь нэмрээ оруулсан байна. 2021 онд өндөглөгчийн 2, 3, 4 дүгээр байрыг барьж ашиглалтанд оруулахаар төлөвлөн ажиллаж байгаа нь цаашдын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна.

2020 оны 5 сарын 25 ны өдрийн ТУЗ-н хурлын шийдвэрээр Голомт банкнаас 2019-2020 оны хооронд авсан байсан богино хугацаатай, өндөр хүүтэй зээлийн эх үүсвэрийг, хүү багатай шинэ эх үүсвэрээр солих зорилгоор Хаан банкнаас 3,4 тэрбум төгрөгийн зээлийн шугам авах шийдвэрийг дэмжиж гаргасан. Энэ хүрээнд уг зээлийг 2020 оны 6-р сард Хаан банкнаас авсан бөгөөд энэ нь компанийн хүүгийн зардлыг бууруулахад эерэг шийдвэр болсон юм. Мөн 2020 оны 11-р сард “Түмэн шувуут” ХК нь ТУЗ-өөс охин компани болох “Усжуулах” ХК-г 2,0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авахад хамтран зээлдэгчээр оролцох асуудлыг дэмжиж шийдвэр гаргасан юм. Тус зээл нь Увс аймгийн Баруунтуруун суманд хэрэгжиж буй төслийг амжилттай хэрэгжихэд түлхэц болно гэж үзсэн болно.

2020 онд компанийн ТУЗ нь сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл батлаагүй болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооноос “Түмэн шувуут” Хувьцаат компанийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэж байна.

Гүйцэтгэх удирдлагын зүгээс компанийн санхүүгийн системдээ дэлхийн олон оронд ашигладаг нэр хүндтэй /Azure/ томоохон үүлэн технологи ашиглаж эхэлж байгааг талархан хүлээж авч байна. “Түмэн шувуут” ХК-ийн санхүүгийн тайлан, мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, санхүүгийн баримт материалын бүрдэл, компанийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн баталсан заавар, журам аргачлал, стандартын дагуу үнэн зөв тайлагнасан болохыг танилцуулж байна.

**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

2021 оны 04 сарын 21-ны өдөр

№ 02/2021

Улаанбаатар хот

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
гишүүдийг сонгох тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.4, “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7, 8.14 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02/2021 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ШИЙДВЭРЛЭХ НЬ:

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан дор дурдсан нэр дэвшигчдийг “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгосугай:
  - 5.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:
    - 5.1.1. Ломбо овогтой Эрхэмбаяр;
    - 5.1.2. Балай овогтой Тунгалаг;
    - 5.1.3. Жигжид овогтой Болд;
    - 5.1.4. Эрхэмбаяр овогтой Баяржаргал;
    - 5.1.5. Эрдэнэчулуун овогтой Жаргалхүү;
    - 5.1.6. Болд овогтой Өлзийбаяр.
  - 5.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
    - 5.2.1. Цэдэв овогтой Наран-Учрал;
    - 5.2.2. Агипар овогтой Бакей;
    - 5.2.3. Гочоо овогтой Мөнх-эрдэнэ;
6. Хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.
7. ТУЗ-ын бүрэлдэхүүний талаарх олон нийтэд мэдээлж, шинээр сонгогдсон гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгосугай.
8. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/-т үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

  


ТҮМЭН ШУВУУТ  
УЛААНБААТАР ХОТ  
2844753  
9019100207  
TUMEN SHUVUUT JSC

Л.ЭРХЭМБАЯР



**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР**

2021 оны 04 сарын 21-ны өдөр  
хот

№ 03/2021

Улаанбаатар

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны цалин урамшууллын хэмжээг тогтоох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15, “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.13, 8.4.14 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 03/2021 тоот тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны цалин урамшууллын хэмжээг хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ж.Болд/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Л.ЭРХЭМБАЯР

